



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2023 оны III улирлын тайлан

ЦАГ ЦАГААРАА БАЙДАГҮЙ

Цаг цагаараа байдаггүй


Банкны салбарын үзүүлэлт харьцангуй тогтвортой, өсөлттэй байлаа. Банкны салбарын нийт актив өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18 хувиар нэмэгдлээ. Иргэдэд хэрэглээний зээл түлхүү олгогдсон бол уул уурхайн салбараас бусад салбарт бизнесийн зээл өсөлттэй, чанаргүй зээл буурч байна. Инфляцын түвшин тогтворжиж, төгрөгийн ханш чангарч буйн улмаас төгрөгийн хадгаламжийн өгөөж, валютын хадгаламжийн өгөөжийг давлаа.

Мөн уул уурхай, тээврийн салбарын сэргэлт нь эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлж, эдийн засаг 6.9 хувиар өсөхөд чухал нөлөө үзүүлжээ. Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан ХАА-н салбар уналттай, бусад салбаруудын өсөлт харьцангуй сул байлаа.

Оны эхнээс эрдэс бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн нь валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн бол гадаад орчны эдийн засгийн нөхцөл сайжирч тээвэр, логистиктой холбоотой зардлууд буурч, импортын өсөлт тогтвортой байгаа нь инфляц, валютын ханшийг тогтвортой байхад нөлөөлжээ.

Төлбөрийн тэнцэл ашигтай байгаа нь валютын нөөцийг нэмэгдүүлж төгрөгийн худалдан авах чадварыг сайжруулжээ. Төсвийн үндсэн тэнцэл ашигтай гарч төсөвт ирэх дарамтыг бууруулж байна.

Уул уурхайн гаралтай эрдэс бүтээгдэхүүний үнэ болон эрэлт тогтмол биш байх үед салбараа дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч явахгүй бол цаг цагаараа байдаггүй, цахилдаг хөхөөрөө байдаггүй гэдэгчлэн нэг л өдөр эрдэс бүтээгдэхүүний үнэ буурч, эрэлт багасвал эдийн засаг элгээрээ хэвтэх эрсдэл өндөр байна.



Иргэдийн хэрэглээний зээлийн өсөлт үргэлжилсээр байна.

Банкууд иргэдэд хэрэглээний зээл буюу цалин, тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээлийг түлхүү олгожээ. Уул уурхайн салбараас бусад салбарт зээл олголт нэмэгджээ.


Онцлох өөрчлөлт, энгийн тайлбар




Иргэдийн зээл олголт, жил бүрийн III улирал

Тэрбум ₮

Онолын тодорхойлолт



Бизнесийн зээл олголт, жил бүрийн III улирал



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Шинээр олгосон зээлийн хэмжээ нэмэгдэв.

45%



2023 оны III улирлын гүйцэтгэл

2023 ОНЫ III УЛИРАЛД БАНКНЫ САЛБАРТ ГАРСАН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА



Банкуудын иргэдэд олгосон зээлийн хэмжээ өсөлттэй байна. Уул уурхайн салбараас бусад салбарын зээл олголт нэмэгджээ.



Банкуудын зээлийн чанар сайжирч байна.



Банкуудын эх үүсвэр өсөлттэй байна.



Системийн нөлөө бүхий 5 банкны санхүүгийн үзүүлэлт өсөлттэй байна.



Системийн нөлөө бүхий банкууд хувьцаа гаргаснаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2 дахин нэмэгдлээ.



Төгрөгийн хадгаламжийн өгөөж валютын хадгаламжийн өгөөжийг давлаа.

БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2023 оны III улирал

Банкны салбарын зээлийн өсөлт үргэлжилсээр байна.


Бодлогын хүү өндөр байгаа хэдий ч иргэдэд олгож буй зээлийн хэмжээ нэмэгдсэн нь банкуудын зээлийн өсөлтөд чухал нөлөө үзүүлжээ.

Банкны зээлийн багц

Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.

+14%

Зээлийн үлдэгдэл
нэмэгджээ.



Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

Салбарын хэмжээнд
чанаргүй зээл

8.5%

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо


Салбарын хэмжээнд зээлийн багцын чанар сайжирчээ.

Иргэдийн хэрэглээний 10 зээл тутмын 1 нь чанаргүй байна.


Салбаруудын эдийн засгийн идэвхжил нэмэгдсэн нь чанаргүй зээлийн хэмжээг буурахад чухал нөлөө үзүүлээ.

Уул уурхайн салбарт олгогдсон чанаргүй зээл өндөр хэвээр байна.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн III улирал




Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн III улирал



Төгрөгийн хадгаламжийн өгөөж нэмэгдсэн нь төгрөгийн эх үүсвэр нэмэгдэхэд нөлөөллөө.

Хугацаагүй хадгаламжид хүү тооцох болсон нь төгрөгийн харилцах 35 хувиар нэмэгдэхэд чухал нөлөө үзүүллээ. Хадгаламжийн хүү нэмэгдэж буй нь иргэдийн хадгалах сонирхлыг нэмэгдүүлж байна.

Банкны эх үүсвэр, жил бүрийн III улирал



Банкны эх үүсвэр

Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Банкны эх үүсвэр

21%

нэмэгджээ.

Банкны жигнэсэн дундаж хүү

Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.

Хадгаламжийн хүү


12%

Эх сурвалж: Монголбанк

Хадгаламжийн хүүгийн өсөлт үргэлжилж байна.

Төв банкнаас гадаад, дотоод эдийн засгийн нөхцөлд үүсэж буй тодорхой бус байдлаас шалтгаалан бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн нь хадгаламжийн хүүг аажмаар өсөхөд нөлөөлжээ.

Эдийн засгийн нөхцөл байдал ирэх улирлуудад сайжирвал бодлогын хүү буурах хүлээлтийг буй болгож байна.



БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2023 оны III улирлын гүйцэтгэл

Банкны актив буюу хөрөнгө

Жич: Банкны нийт өр төлбөр дээр нэмэх нь эздийн өмчийг бүхэлд нь банкны хөрөнгө буюу актив гэнэ.

Системийн нөлөө бүхий
банкуудын актив

18%


ӨСӨВ.

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Банкны системийн нийт актив өмнөх оны мөн үеэс 6.8 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

ХасБанкны актив 24 хувиар, ХААН Банкны актив 22 хувиар, ХХБ-ны актив 16 хувиар тус тус өссөн нь банкны салбарын активын өсөлтөд чухал нөлөө үзүүлжээ.


Банкуудын актив, жил бүрийн III улирал



Банкны салбарын нийт эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.8 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

ХХБ болон ХААН Банкны эх үүсвэр 1.5 их наяд төгрөгөөр, Голомт банкны эх үүсвэр 1.2 их наяд төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Банкуудын эх үүсвэр, жил бүрийн III улирал



2021	2022	2023
Хаан		
ХХБ		
Голомт		
Төрийн банк		
Хас		

Банкны эх үүсвэр

Жич: Иргэд, байгууллага болон хөрөнгө оруулагчдаас татсан өр төлбөрийн хэмжээ.

Банкуудын эх үүсвэр

18%

НЭМЭГДЖЭЭ.

Өөрийн хөрөнгийн өгөөж

Жич: Тухайн байгууллага нь өөрийн хөрөнгөө хэр үр ашигтай зарцуулж буй тухай мэдээлэл өгдөг. Өөрөөр хэлбэл, компани хөрөнгийг хэрхэн ашиг болгож буйг илэрхийлдэг үзүүлэлт юм.

Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж дунджаар


14.8%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Зарим банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж хадгаламжийн өгөөжөөс илүү байна.

Системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн дүн 4.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 10 хувиар өсжээ. Өөрийн хөрөнгөөр буй болгосон ашгийн хэмжээ өндөр хэвээр байна.


Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж, жил бүрийн III улирал



Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ нэмэгджээ.

Банкууд эдийн засгийг дэмжих, гол салбаруудын сэргэлтийг нэмэгдүүлэх хангалттай өөрийн хөрөнгөтэй байна.

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, жил бүрийн III улирал



2021	2022	2023
Хаан		
ХХБ		
Голомт		
Төрийн банк		
Хас		

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Жич: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг хэлдэг

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний дундаж

18%

Хөрвөх чадварын харьцаа

Жич: Богино хугацаат төлбөрүүдийг цаг тухайд нь төлөх чадварыг хэмждэг харьцаа.


Системийн нөлөө бүхий банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийн дундаж

39%

Системийн нөлөө бүхий 5 банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр байна.

Банкууд цаашид эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэхэд хангалттай хэмжээний хөрөнгөтэй байна.

Банкуудын хөрвөх чадварын харьцаа, жил бүрийн III улирал



2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023
Хаан			ХХБ			Голомт			Төрийн банк			Хас		


МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

2023 оны III улирал: Эдийн засгийн өсөлт 6.9 хувьтай гарлаа. Оны эхнээс уул уурхайн салбар, түүнийг дагаад тээвэр, агуулахын салбарын сэргэлт харьцангуй хурдан байсан нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлжээ. Боловсруулах, эрчим хүч болон худалдаа, үйлчилгээний салбарт сэргэлт ажиглагдаж буй хэдий ч энэхүү сэргэлт нь харьцангуй сул байна. ХАА-н салбар сүүлийн 3 улирал дараалан уналттай байна. Эрэлтийн талаас нь харвал, хэрэглээ болон экспорт нэмэгдсэн нь эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүлжээ.

Төлөв байдал: Дэлхийн томоохон Төв банкуудын хэрэгжүүлж буй мөнгөний хатуу бодлого нь глобал санхүүгийн зах зээлийн өсөлтийг хязгаарлаж буй бол БНХАУ-ын эдийн засгийн төлөвийн талаарх хүлээлт сайн биш байгаа нь уул уурхайн бүтээгдэхүүний үнийн төлөвт сөргөөр нөлөөлөх тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байна. Иймд цаашид уул уурхайн салбараас бусад эдийн засгийн салбарыг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг авахгүй бол эдийн засгийн өсөлтийг хадгалахад ихээхэн хүндрэлтэй нь харагдаж байна.


2023 оны III улирлын байдлаар эдийн засаг 6.9 хувиар өсөв.

Уул уурхайн салбарын сэргэлт нь тээвэр, агуулахын салбарыг хурдацтайгаар дэмжсэнээр эдийн засгийн өсөлтийн дийлэнх хувийг буюу 5.5 хувийг бүрдүүлж байна. Боловсруулах, эрчим хүч болон худалдаа, үйлчилгээний салбарт сэргэлт ажиглагдаж буй хэдий ч хангалттай түвшинд биш байна. Барилгын салбарт өсөлт ажиглагдахгүй байгаа бол ХАА-н салбар сүүлийн 3 улирал дараалан буурчээ.



Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага өндөр байна.


Импортын хэмжээ буурч, экспортын хэмжээ нэмэгдсэн нь цэвэр экспортын хэмжээг нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүлжээ. Засгийн газрын болон өрхийн хэрэглээний өсөлт нь эдийн засгийг эрэлтийн талаас нь нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлжээ. Гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх онтой харьцуулахад 2 дахин буурчээ.




Гадаад худалдааны тэнцэл өмнөх оны мөн үеэс 77 хувиар өсжээ.

Нүүрсний экспорт 53 хувиар, алтны экспорт 26 хувиар нэмэгдсэн нь худалдааны тэнцэл ашигтай гарахад чухал үүрэг гүйцэтгэлээ. Гадаад зах зээл дээр үнэ тогтворжсон нь импортын үнийн өсөлтийг саарууллаа.

Уул уурхайн гаралтай эрдэс бүтээгдэхүүн болон ХАА-н бүтээгдэхүүн нь **экспортын өсөлтөд** эерэг нөлөө үзүүлжээ.



Гадаад орчны эдийн засаг харьцангуй тогтворжсон нь **импортын өсөлтийг** буурахад нөлөөлжээ.



Экспортын нөхцөл байдал сайжирч **худалдааны тэнцэл ашигтай** байна.




Төлбөрийн тэнцэл ашигтай байж ханш тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлээ.


Гадаад орчинд үнэ тогтворжиж, импортын өсөлтөөс илүүтэйгээр экспорт нэмэгдсэн нь төлбөрийн тэнцэл 791.4 сая ам.долларын ашигтай гарахад нөлөөллөө. Гадаадын хөрөнгө оруулалтын гарах урсгал үргэлжилсээр байна.

Төгрөгийн бодит ханш аажмаар чангарч манай улсын бараа, бүтээгдэхүүн бусад улстай харьцуулахад үнэтэй болж байна.

Төгрөгийн нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш



Төлбөрийн тэнцэл оны эхнээс ашигтай байна.




Инфляцын түвшин алгуур буурч төгрөгийн хадгаламжийн өгөөж нэмэгдэж эхэллээ.

Гадаад орчны нөхцөл байдал сайжирч нийлүүлэлтийн гаралтай инфляц алгуур буурч байна.

Хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ нэмэгдсэн нь хэрэглээний улсын индексийн 40 орчим хувийг бүрдүүлж байна.


Импортын 5 сарын хэрэглээг хангах валютын нөөцтэй байна.

Сая ам.доллар



Инфляцын түвшин аажмаар буурч төгрөгийн хадгаламжийн өгөөж эерэг болж эхэллээ.

Хувиар




Төсвийн тэнцэл 2.1 их наяд төгрөгийн ашигтай гарлаа.


Урсгал зардал, тэр дундаа цалин хөлс болон бусад бараа бүтээгдэхүүний зардал нь төсвийн зарлагын дийлэнх хувийг бүрдүүлж байна. Сүүлийн жилүүдэд төсвийн үндсэн тэнцэл ашигтай гарч төсвийн алдагдлын дарамт буурч байна. Уул уурхайн салбарын сэргэлт нь төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүллээ.

Төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 40 хувиар нэмэгджээ.


ДНБ-д эзлэх хувиар



Төсвийн зарлага өмнөх жилтэй харьцуулахад буурчээ.




Төсвийн зардал буурч орлого нэмэгдсэнээр **төсөв ашигтай** гарчээ.




БАНКНЫ САЛБАРЫН ХҮРТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



100,000 хүнд оногдох банкны салбар, нэгжийн тоо өндөр байна.



ЖДҮҮ шинээр олгогдож буй зээлийн хэмжээ сонгосон улсуудтай харьцуулахад боломжийн түвшинд байна.



Худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлж буй ЖДҮҮ эрхлэгч иргэдэд зээлийн дийлэнх хэсгийг олгож байна.

